



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2024 оны
4 сар

Нийгмийн даатгалын санд 2024 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар 1,258.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 96.1 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 554.5 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал болон бусад зардалд нийт 1,558.6 тэрбум төгрөг зарцууллаа. 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн албан хаагчийн тэтгэвэр, зарим иргэний тэтгэвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээний зардалд улсын төсвөөс 559.5 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлэв.


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын санд энэ оны 4 дүгээр сарын байдлаар нийт 1,258.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 266.8 тэрбум төгрөгөөр өсжээ.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд :

- Тэтгэврийн даатгалын санд 82.1% буюу 1,032.7 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 8.7% буюу 109.3 тэрбум төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 6.0% буюу 75.6 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 3.2% буюу 40.9 тэрбум төгрөг;


Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

2024 оны 4 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал болон бусад зардалд нийт 1,558.6 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 374.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Нийгмийн даатгалын сангийн зарлага, тэрбум төгрөгөөр



ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН

Тэтгэврийн даатгалын санд 4 дүгээр сарын байдлаар 1,032.7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэн улсын төсвөөс 557.8 тэрбум төгрөгийг хүлээн авсан. Тус сангаас өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 498.0 мянган хүний тэтгэвэрт 1,434.9 тэрбум төгрөг, бусад зардалд 169.8 сая төгрөг зарцуулав. Тэтгэврийн даатгалын сангийн нийт зардлын 80.7 хувь буюу 1,158.1 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 393.0 мянган хүний тэтгэвэрт зарцуулсан байна.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр




ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН

Тэтгэмжийн даатгалын санд 109.3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэв.

Энэ оны 4 дүгээр сарын байдлаар тус сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авсан 42.7 мянган хүний тэтгэмж болон гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн шимтгэлд 69.4 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт тэтгэмжийн даатгалын сангийн зардлын 74.5 хувь буюу 51.7 тэрбум төгрөгийг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид зарцуулсан байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр




ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 75.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн улсын төсвөөс 1.7 тэрбум төгрөгийг хүлээн авсан.

Энэ оны 4 дүгээр сарын байдлаар 4.4 мянган хүний хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж, даатгуулагчийн эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрт нийт 14.2 тэрбум төгрөг зарцуулав.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага, сая төгрөгөөр



АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН

Ажилгүйдлийн даатгалын санд 4 дүгээр сарын байдлаар нийт 40.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 9.4 мянган хүний ажилгүйдлийн тэтгэмжид 39.9 тэрбум төгрөг зарцуулав. Сангийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.8 тэрбум төгрөгөөр, зарлага 6.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр

